



ADVENTIST DEVELOPMENT  
AND RELIEF AGENCY



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT



## ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ТҮНШЛЭЛ ТӨСӨЛ

**ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗАР:** Сэлэнгэ аймаг, 11 сум

**ТӨСЛИЙН ХАМТРАН АЖИЛЛАДАГ ХОРШООД:** 11 сумын 30 хоршоо, тэдгээрийн 928 гишүүн, Сэлэнгэ Таван Хайрхан Дундын Хоршоо

**ТӨСЛИЙН САНХҮҮЖҮҮЛЭГЧ:** ХБНГУ-ын Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн яам, АДРА Герман

**ТӨСЛИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:** 4,3 жил

2018оны 10 дугаар сарын 1 нээс -2022 оны 12 дугаар сарын 31

**Нийт төсөв: 1,118,064 евро** (3,423,439, 871 төгрөг)

2022 оны төсөв: 526,942 төгрөг

**Хамтран ажиллагч байгууллага:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, Сэлэнгэ Таван Хайрхан дундын хоршоо, бусад ОУБ-ын төсөл хөтөлбөрүүд

### ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Сэлэнгэ аймагт хөгжүүлэн, хамтын баталгаажуулалтын тогтолцоог бий болгож, талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, бага талбайд тариалан эрхлэгч иргэдийн амьжиргааг сайжруулна.

### ТӨСЛИЙН ЗОРИЛТ:

1. Орон нутгийн ба үндэсний түвшинд байгуулагдсан олон талт түншлэлийн хүрээнд талууд органик хөдөө аж ахуйг бэхжүүлэхэд чиглэсэн шаардлагатай асуудлуудыг ярилцаж, шийдвэрлэдэг бүтэц, механизмыг бий болгосон байна.
2. 30 хоршооны бүтээгдэхүүн үйлдвэрлэл сайжирч, төрөл нэмэгдэж, тогтворжсон байна.
3. Олон талт түншлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлснээр 30 хоршооны орон нутаг ба бүс нутгийн зах зээлд нэвтрэх боломж нэмэгдсэн байна.

“Органик хөдөө аж ахуйн түншлэл” төсөл нь Сэлэнгэ аймгийн 11 сумын 30 анхан шатны хоршооны **928 (эм335/эр593)** гишүүнтэй хамтран ажиллаж байна.

**Зохион байгуулсан сургалтууд:** 2022 оны эхний хагас жилийн байдлаар **органик хөдөө аж ахуй хамтын баталгаажуулалт, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх даршлах нөөшлөх цехийн дотоод хяналт, ул мөрийг мөшгөн мөрдөх стандарт сургалт, хоршооны засаглал, манлайлалын зэрэг 9 удаагийн сургалтад 722 (эм 579/эр 143)** хоршооны гишүүд, төрийн байгууллагын ажилтнууд, хамтран ажиллагч талуудын төлөөллийг оролцуулсан байна.

**Шинээр 32 ногоочин, зөгийчин тангараг өргөлөө:** Органик үйлдвэрлэлийн стандарт журмуудыг танилцуулах сургалтад хамрагдсан 32 ногоочин, зөгийчин органик үйлдвэрлэгчийн тангарагаа 2022 оны 3 дугаар сард өргөлөө. Ингэснээр төсөл эхэлснээс хойш 327 хоршооны гишүүн тангараг өргөсөн байна.



**Сэлэнгэ Органик дэлгүүрийг Улаанбаатар хотод дахин нээлээ:**

Улаанбаатар хотод байгуулсан “Сэлэнгэ органик” брэнд бүтээгдэхүүний дэлгүүрээр жилийн турш борлуулдаг. Ийнхүү Сэлэнгийн органик ногоочид “Сэлэнгэ органик” брэндийг хөгжүүлэхийн төлөө сэтгэл нэгдэн ажиллаж байна.

**Шаардлагатай үр бордоог хоршоодод олголоо:**

Органик газар тариалангийн шаардлагад нийцсэн, ховор олдоцтой 28 төрлийн 14 сая төгрөгийн үрийг 2022 оны 1 дүгээр сард хоршоодод тарааж өглөө. Төсөл эхэлснээс хойш нийт 78,9 сая төгрөгийн үр бордоог хоршоодод өгсөн байна.




Зураг 1. Өлгий Ерөө хоршооны дарга Оюунчимэг үрээ хүлээн авч байна.

Зураг 2. Ерөө Бугант хоршооны дарга Энхцэцэг үрээ хүлээн авч байна.

**Германы Хамтын Удирдлагын Институтын зохион байгуулсан онлайн хуралд илтгэл тавилаа.**

Органик хөдөө аж ахуйн түншлэл төслийн хэрэгжүүлж буй нэг гол арга зүй нь Олон талт түншлэлийн арга зүй юм. Уг арга зүйг Германы Хамтын Удирдлагын Институт боловруулсан. Олон талт түншлэлийг ашиглан органик хөдөө аж ахуйн нэмүү өртөг дэх талуудын бүтээлч, үр дүнтэй оролцоог бий болгож байгаа туршлагаа 2022 оны 2 дугаар сарын 24-ын онлайн хуралд төслийн менежер Г. Цэцгээ тавьж танилцууллаа.





**Органик бордоо ХББ-ыг байгууллаа.**

Дархан-Уул аймгийн Био-Ундарга старт ап компани, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Ширхэнцэг өгөөж хоршоо, Жавхлант сумын Бумбат таван богд хоршоо хамтран Органик бордоо ХББ-ыг үүсгэн байгуулж, ХХААХҮЯ-ны бүртгэлийн системд бүртгүүлээ. ХББ-ын гишүүд 2022 оны 3 сард Био-Ундарга компанийн Ризо болон Жига бордоонд төлөвлөгөөт хяналт хийлээ. Бордооны ул мөрийг мөшгөн мөрдөх дэвтрийг төслийн зүгээс боловсруулж өглөө.



**Мандал сумын ногоочдын зөвлөгөөн-** Мандал сумын ЗДТГ-ын санаачлагаар зохион байгуулагдсан. Уг зөвлөгөөнд Органик хөдөө аж ахуйн түншлэл төслийн ололт амжилт, тулгамдаж буй асуудлуудын талаар төслийн менежер Г. Цэцгээ 2022 оны 3 дугаар сарын 15ны өдөр илтгэл тавьж, сонирхсон асуултад хариуллаа. Уг зөвлөгөөнд Мандал сумын 800 гаруй ногоочид оролцсон.






**Олон улсын ICAD байгууллагын орон нутгийн хөгжлийн гарын авлага номд АДРА ОУБ-ын Органик хөдөө аж ахуйн түншлэл төслийн сайн туршлагыг бичиж нийтлүүллээ. Уг номын зохиогчийн урилгаар өөрийн кэйсийг подкастад 2022 оны 3 сард оролцон танилцууллаа.**

**Сэлэнгэ органик брэнд бүтээгдэхүүний борлуулалт:**

2022 оны эхний хагасын байдлаар Сэлэнгэ таван хайрхан дундын хоршоо органик бүтээгдэхүүнийг 3 дэлгүүр, 3 компанид нийлүүлэн, 2 удаагийн үзэсгэлэн худалдаанд оролцож 50 орчим сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

**Органик хүнс боловсруулах даршлах, нөөшлөх цех, органик бордооны үйлдвэрлэлийн үл мөрийг мөшгөн мөрдөх дэвтэрүүдийг шинээр боловсруулж, үйлдвэрлэл эрхлэгч хоршоодоор хэлэлцүүлж сайжрууллаа.**



**Органик ногоогоор хийх 5 төрлийн видео хичээлийг хоол зүйч, доктор Н.Оюундарьтай хамтран хийж, Youtube-д байрлууллаа.**

1. Органик ногоогоор шаржигнуур байцааны салат хийх хичээл №1  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/715436496265561>
2. Органик ногоогоор бие цэвэрлэх смүүти хийх хичээл №2  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/2809715746004119>
3. Сыртэй битүү хайрсан брокколи, цэцэгт байцаа хийх хичээл №3  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/1048949259384506>
4. Органик ногоогоор шоштой шөл хийх хичээл № 4  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/968816883805228>
5. Органик ногоогоор ногооны шорлог хийх хичээл №5  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/689900258972839>

Органик хөдөө аж ахуйн түншлэл төсөл 2019-2022 онд оруулсан шууд хөрөнгө оруулалтыг харуулбал:

#	Хөрөнгө оруулалтын хэлбэр	Мөнгөн дүн төгрөгөөр
1.	Газар тариалангийн тоног төхөөрөмж	193,960,170
2	Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйдвэрлэх тоног төхөөрөмж (ногоо даршлах нөөшлөх, зөгийн бал савлах, талх нарийн боов, оёдол, эсгий бүтээгдэхүүн, органик бордоо үйлдвэрлэх, мах ангилан ялгах гм 33 цех)	150,506,494
3	Органик үр бордоо	78,962,305
4	Бүтээгдэхүүн хөгжүүлэлт-169,300 ширхэг сав баглаа боодол, 140,280 ширхэг шошго	72,700,600
	Нийт шууд хөрөнгө оруулалтын дүн	<b>496, 129, 569</b>

Төслийн зүгээс бэлтгэн эвлүүлсэн видео линкүүд

6. Органик хөдөө аж Органик хөдөө аж ахуйн түншлэл төсөл 2019 онд  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/576727199806257>
7. Харандааны түүх <https://www.facebook.com/selengeorganic/videos/689829041631758>
8. Органик хөдөө аж ахуй гэж юу вэ?  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/806101916606642>
9. Органик хөдөө аж ахуй, хамтын баталгаажуулалт  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/3777449805655535>
10. Органик хүнсний хамтын баталгаажуулалт гэж юу вэ?  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/3054972064730892>
11. Органик хөдөө аж ахуйн түншлэл төсөл 2021 онд  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/618125732596031>
12. Органик ногоогоор шаржигнуур байцааны салат хийх хичээл №1  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/715436496265561>
13. Органик ногоогоор бие цэвэрлэх смүүти хийх хичээл №2  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/2809715746004119>
14. Сыртэй битүү хайрсан броккли, цэцэгт байцаа хийх хичээл №3  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/1048949259384506>
15. Органик ногоогоор шоштой шөл хийх хичээл № 4  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/968816883805228>
16. Органик ногоогоор ногооны шорлог хийх хичээл №5  
<https://www.facebook.com/selengeorganic/videos/689900258972839>



Зураг1. Сэлэнгэ аймаг Алтанбулаг сум, Баяжих сүүн булаг хоршоо



Зураг 2. Сэлэнгэ аймаг Шаамар сум Органик бал хоршооны гишүүн Ё. Оюунцэцэг



Зураг3. 2020 оны аймгийн шилдэг хоршоо, Сант сумын Усан хээр хоршоо



Зураг 4. Сэлэнгэ органик брэнд бүтээгдэхүүний дэлгүүр. УБ хот



*Зураг 5. АДРА ОУБ, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-тай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа*



*Зураг 6. Мандал сумын Агро тариалалт борлуулалт хоршоо*



*Зураг7. Мандал сумын Зүүн хараа баялаг хоршооны гишүүн Хорлоо*



*Зураг8. Баянгол сумын Хараагийн баян үрс хоршоо*



*Зураг9. Мандал сум Тансаг цагаан идээ хоршоо*





Зураг10. Мандал сумын Ширхэнцэг өгөөж хоршоо жилдээ 100-150тн органик бордоо үйлдвэрлэхээс гадна хоол амтлагч 6 төрлийн ногоо тарьж ургуулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.



Зураг11. Сэлэнгэ Таван Хайрхан Дундын Хоршоо оны шилдэг органик үйлдвэрлэгч шагналаар шагнагдлаа.



*Зураг12. Сэлэнгэ Таван Хайрхан Дундын Хоршооны дарга Ч. Оюунтуяа МУ-ын шилдэг хоршооны шагналыг ХХААХҮЯ-ны сайд Мэндсайханаас гардан авч байна. 2021 оны 12 дугаар сарын 24*